

**ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2025.06.10

Д/д	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг албан хаагчдад сурталчлах, сургалт зохион байгуулах чиглэлээр		
1	Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын хувьд эрхэлж байгаа ажил үүргийн онцлогтой холбогдон өртөж болзошгүй гэмт хэрэг, зөрчил түүний үр дагаварын талаар мэдээлэл, сэрэмжлүүлэг өгөх	Хэлтсийн сургалтын төлөвлөгөөнд эрхэлж байгаа ажил үүргийн онцлогтой холбогдуулан өртөж болзошгүй гэмт хэрэг, зөрчил түүний үр дагавар сэдэвт онлайн сургалтыг хийсэн.
2	Авиглын эсрэг үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж нийт албан хаагчдад сургалт зохион байгуулах.	Авиглын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлагналтыг хэрэгжилтийн хүрээнд хэлтсийн ажлын байранд Авлига, зөвлөгүүдийн тайлагналт нэртэй мэдээллийн самбарыг шинээр хийж дотор нь Авиглын эсрэг хамтдаа гэсэн уриатай булан ажиллуулж мэдээ мэдээлгүүдийг байршуулан ажиллаж байна. “Авлига албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт 2 цагийн хичээлийг Аймгийн прокурорын газрын Ахлах прокурор Сансарбаяр болон АЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн Ариунзааа нар зааж Хэлтсийн албан хаагчид Авиглын эсрэг нэгдлээ.
3	Зөрчлийн тухай хуулийг сурталчлах, зөрчил гаргахгүй байх талаар иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэх.	Иргэн, хуулийн этгээдүүдэд баримт бичгийн зөрчил гаргахгүй байх талаар мөн өөрт холбоотой бүртгэлийг хуулийн хугацаандаа улсын бүртгэлд бүртгүүлэх талаар, Баримт бичгийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар үйлчилгээний зааланд гарын авлага, тарааж өгөх материал боршурыг байршуулан ажилласан. Мөн Хэлтсийн пэйж хуудас болон бусад сошиал орчноор дамжуулан бүртгэлтэй холбоотой бүрдүүлэх бичиг баримтын талаар болон хугацааны талаар байнга заавар зөвлөгөөг оруулан ажилласан. Сумдын улсын бүртгэгч нар өөрсдийн фэйсбүүк хуудас болон сумдын групп дээрээ иргэний үнэмлэхний 25, 45 насны сунгалтын зарыг хүргэхээс гадна сунгалтаа хийлгэх насанд хүрсэн иргэдийн

		судалгааг багийн ажлын албанаас авч тэдгээр иргэд рүү утасдаж иргэний үнэмлэхний сунгалтын хугацааг сануулж хэлдэг шинэлэг ажлыг санаачлан зохион байгуулж ажиллаж байгаа. Ингэснээр хугацаа хэтэрсэн торгуулийн арга хэмжээ авагдахгүй хэвшсэн. Харин Улиастай, Тосонцэнгэл сумдад хүн ам ихээр төвлөрсөн учраас зөрчлийн дагуу торгуулах үйлдэл гардаг.
4	Үйлчилгээний зааланд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга, санамж материалыг байршуулах, тараах байгууллагын веб хуудсанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл байршуулах.	Хэлтсийн байранд шинээр байршуулсан Авлига, зөвлөгүүдийн тайлагналт нэртэй мэдээллийн самбарт гэмт хэргээс урьдчилан сэргийлбэ нэртэй буланг ажиллуулж шаардлагатай мэдээллийг тавьж солих хариуцан ажиллаж байна.
5	Шинээр батлагдсан хууль тогтоомж, эрх зүйн актын талаар нийт албан хаагчдад тогтмол мэдээлэх.	Өнгөрсөн онд шинээр эрх зүйч мэргэжил эзэмшиж эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн эрх авсан Тэлмэн, Нөмрөг, Тэс, Их-Уул, Цагаанчулуут, Сантмаргац, Асгат, Тосонцэнгэл, Баянтэс, Цагаанхайрхан, Нөмрөг, Цагаанчулуут, Сантмаргац, Их-Уул, Сонгино, Тэлмэн, Тэс сумдын сумын улсын бүртгэгчидийн хийсэн бүртгэлийг Хяналтын улсын байцаагч, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга нар шалгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан. 5 сарын 1 нд “Хуульчийн про боно өдөр 2025” Хууль зүйн мэдээлэл өдөрлөгт аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран оролцож Завхан аймгийн Политехникийн коллежийн оюутан сурагчдад 3 төрлийн бүртгэлийн талаар мэдээлэл өгч мөн оюутан сурагчдын дунд Үсэглэлийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж ажилласан. 5 сарын 29 нд Монгол Улсад Нисэх хүчин үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ой, Эх оронч монгол-Их сэрэлтийн жилийн хүрээнд Олон улсын энхийг сахиулагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, Завхан аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлах, энхийг сахиулагчдын алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор Хуулийн байгууллагуудын зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдөрт оролцож Зөөврийн тоног төхөөрөмж ашиглан 3 төрлийн бүртгэл хийлээ. Мөн аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран “Гэрлэлтийн батлах гардуулах ёслол” -ыг 4 дэх жилдээ зохион байгууллаа.

Хоёр. Улсын бүртгэлийн нэгдсэн сангийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр


1	Мэдээллийн болон кибер орчны аюулгүй байдлын талаар албан хаагчдын дунд тодорхой мэдлэг, ойлголт олгох ажлын олгох зорилгоор мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг шалтгаан, нөхцлийг судлан түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.
2	Бүртгэлийн үйл ажиллагааны талаар шинээр гарсан мэдээ мэдээллийг байгууллагын вэб сайт хуудас болон ажигтнууд өөрсдийн фэйсбүүк хуудсаар дамжуулан сурталчилсан. Хэлтсийн хэмжээнд Улсын бүртгэлийн мэдээллийн системийг ашиглаж байгаа нийт 36 албан хаагч байгаа бөгөөд эдгээр албан хаагчид бүртгэлийн программд нэвтрэх нууц кодоо улирал тутамд сольж хэвшсэн. Мөн хэлтсийн хэмжээнд эд хөрөнгө болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжийг 2010 оноос хойш ахиж солиогүй байгаа. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Эд хөрөнгийн бүртгэлийн тасагт 1 компьютер өгснийг үйлчилгээний зааланд суурилуусан. Хэлтсийн мэдээлэл технологийн ажигтан нь байгууллагын дотоод сүлжээ болон тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангаж тэдгээрт эвдрэл гэмтэл гарсан үед нь цаг алдалгүй засаж, хэвийн горимд ажиллуулах, шаардлагатай тохиолдолд шинээр сэлбэг авч суурилуулах, ажигтнуудын компьютерт вирусны эсрэг лицензтэй программ хангамжийг байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан ээлж дараатай хийж байна. Хууль хяналтын байгууллагад иргэний бүртгэлийн чиглэлээр 233, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 55 лавлагаа гаргаж тус тус хүргүүлсэн. Киоскийн машинаар 2660 лавлагаа олгосон байна. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн эх нотлох баримтын архивт эх нотлох баримтыг эмх цэгцтэй байршуулж, үйлчилгээ орсон хувийн хэргүүдэд цаг тухай бүрд нь холбогдох баяжилтыг хийж байгаа. Мөн эд хөрөнгийн бүртгэлийн архивын цэнхэр хавтсыг стандартад нийцсэн цаасан хавтсаар солих ажил хийгдэж байгаа. Архивуудад галын хорны аюулгүй байдлыг хангаж сар бүр шалгаж, өдөр тутам тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Архивыг өдөр бүр пацдаж түлхүүрийг жижүүрт өгч хэвшсэн.

Гурав. Гэмт хэргийн шинжтэй санал, гомдол, мэдээллийг хүлээн авч шуухай шийдвэрлэх чиглэлээр

1	Байгууллагын болон албан хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэн байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй санал гомдол, мэдээллийг хүлээн авч шуурхай шийдвэрлэж ажиллах.	Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй санал гомдол, мэдээлэл байхгүй болно. Аймгийн төвийн 6 баг дээр Төрийн үйлчилгээг багт гэсэн аяны хүрээнд манай байгууллага оролцож нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэхээс сэргийлэх, бүрдүүлэх материал болон бүртгэлд бүртгүүлсний ач холбогдлын талаар зөвлөгөө мэдээлэл өгч иргэдийн сонирхсон асуултанд хариулж ажилласан.
2	Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах шалгалт хийх, хяналт шалгалтаар тайлан дүгнэлт, зөвлөмж гаргаж түүний мөрөөр арга хэмжээ авсан байх	Дотоод хяналтыг улсын бүртгэгч Ч.Баасанжав хариуцаж ажилтнуудад сар бүр тогтмол хяналт хийдэг бөгөөд тайлант хугацаанд гарсан зөрчилгүй болно.
Дөрөв. Улсын бүртгэлийн хэлтсийн ажлын байрны аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр		
1	Хэлтсийн ажлын байрны аюулгүй байдлыг хангах, камер дохиоллын системийн хэвийн ажиллагааг хангах.	Гэрээт ажилтнуудад бүртгэлийн байгууллагын онцлог, архивын өрөөний хадгалалт хамгаалалт, ус чийг алдах янз бүрийн эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд өрөө тасаглааг оройд үзэж шалгаж байх хэрэв янз бүрийн эрсдэл гарсан тохиолдолд цаг алдалгүй арга хэмжээ авах талаар сургалт зохион байгуулсан. Аймгийн онцгой байдлын галын байцаагчаар 2025 оны 04 сард Галын аюул, Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх сэдэвт 1 цагийн сургалтыг Хэлтсийн бүх албан хаагчдад оруулсан. Хэлтсийн байр нь 15 хяналтын IP камертай. Мөн хулгайн дохиоллын системтэй, галын утаа мэдрэгч системтэй бөгөөд эдгээр төхөөрөмжүүд нь одоогоор хэвийн ажиллаж байна.
2	Нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүр томилогон ажиллуулах	Ямар нэгэн эрсдэл болон халдлага гарсан үед ажиллах, ажилтнуудыг хурдан цуглуулах схемийн хуваарийг Хэлтсийн даргын тушаалаар батласан ба ингэснээр ажлын байран дахь гэмт хэрэг зөрчил, гамшигийн эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

УЛСЫН БҮРТГЭГЧ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН



Н.НАРАНБИЛЭГ